



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/17

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4, 3.4.3, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус тосгонд 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ковш худалдан авах гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Отгонбаяр – Захирагчийн ажлын албаны дарга

Гишүүд: Н.Ганцэцэг – Нярав

О.Амаржаргал - Жолооч

Т.Хаш-Эрдэнэ - Галч

Д.Отгонбаяр – Иргэн

2. Ковш худалдан авах гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ